



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|--------------------------------------------------------------------------------|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ..... | |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд | 11 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 12 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 14 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 14 |
| 4.2 Материаллаг байдал..... | 14 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 15 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 16 |
| 4.4.5.1 Завсрын аудитын талаар..... | 16 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 16 |
| 5.1 Залруулга..... | 16 |
| 5.2 Албан шаардлага | 16 |
| 5.3 Зөвлөмж..... | 17 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УТХО | Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.БАТТӨМӨР
ТАНАА**

2022.02.25 № 103

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс 1,263,093.3 мянга, орон нутгийн төсвийн 233,843.4 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 12,333.4 мянга нийт 1,509,270.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,427,643.4 мянган төгрөг зарцуулж, төсөвт 22,270.2 мянган төгрөг төвлөрснийг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|-----------------------------------------------------------------------|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>43,142,567.54</u> | <u>127,439,127.15</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 59,356,510.21 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 59,356,510.21 |
| 3121 | Төгрөг | - | 59,356,510.21 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 59,356,510.21 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 43,142,567.54 | 68,082,616.94 |
| 351 | Түүхий эд материал | 465,000.00 | - |
| 35130 | Эм боох материал | 465,000.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 40,037,567.54 | 63,507,116.94 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,379,230.71 | 45,706,923.71 |
| 35460 | Хүнсний материал | 279,750.00 | 1,771,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,378,586.83 | 16,028,593.23 |
| 35600 | Мал амьтад | 2,640,000.00 | 4,575,500.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>772,153,286.50</u> | <u>839,601,115.02</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 772,153,286.50 | 839,601,115.02 |
| 392 | Биет хөрөнгө | 736,101,286.50 | 783,991,115.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 826,838,100.00 | 826,838,100.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (137,988,398.88) | (187,476,851.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 19,800,000.00 | 19,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (6,875,000.00) | (10,175,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 131,922,953.27 | 172,124,686.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (114,455,498.41) | (75,111,119.05) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 72,074,342.39 | 50,135,344.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (60,360,511.87) | (17,389,066.85) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 100,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (277.80) |
| 39217 | Ном | 5,145,300.00 | 5,145,300.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 36,052,000.00 | 55,610,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,687,789.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,687,789.00) | (100,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 36,052,000.00 | 54,210,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>815,295,854.04</u> | <u>967,040,242.17</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | <u>555,073.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 555,073.00 |
| 413 | Өглөг | - | 555,073.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 555,073.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>815,295,854.04</u> | <u>966,485,169.17</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 815,295,854.04 | 966,485,169.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 522,082,593.56 | 522,082,593.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 522,082,593.56 | 522,082,593.56 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (114,723,162.16) | 36,466,152.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (114,723,162.16) | (930,019,016.20) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 966,485,169.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 407,936,422.64 | 407,936,422.64 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>815,295,854.04</u> | <u>967,040,242.17</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,204,087,809.54 | 2,427,090,272.44 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,076,459.54 | 930,153,541.44 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,076,459.54 | 930,153,541.44 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,868,150.54 | 930,153,541.44 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 3,443,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 8,890,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 7,868,150.54 | 917,820,141.44 |
| 120009 | Бусад орлого | 208,309.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,196,011,350.00 | 1,496,936,731.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,026,885,200.00 | 1,263,093,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,263,093,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,026,885,200.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,595,250.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,762,250.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,833,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 156,530,900.00 | 233,843,431.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 156,530,900.00 | 233,843,431.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,255,869,208.24 | 1,460,585,103.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,255,869,208.24 | 1,460,585,103.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,174,368,006.69 | 1,357,764,053.66 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 818,806,375.13 | 938,727,738.56 |
| 210101 | Үндсэн цалин | 568,954,578.13 | 677,506,432.05 |
| 210102 | Нэмэгдэл | 178,151,175.00 | 210,029,460.39 |
| 210104 | Урамшуулал | 71,700,622.00 | 51,191,846.12 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,884,853.13 | 107,363,921.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,456,753.13 | 73,512,640.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,607,000.00 | 8,609,957.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,085,599.97 | 6,881,245.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,521,400.00 | 1,669,097.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,214,100.03 | 16,690,980.66 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 131,285,983.19 | 155,201,590.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,252,889.19 | 8,578,966.39 |
| 210302 | Түлш, халаалт | 125,720,094.00 | 146,192,624.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 313,000.00 | 430,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,059,018.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,067,650.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,478,250.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 825,818.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 3,163,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 494,600.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,029,700.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 22,609,608.00 | 24,938,480.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,389,100.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 19,958,508.00 | 24,938,480.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,262,000.00 | - |

| | | | |
|-------------|-----------------------------------------------------------------------------|------------------------|-----------------------|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 4,278,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,278,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 394,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 394,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,405,900.00 | 12,217,490.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,541,900.00 | 3,443,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 8,774,090.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 74,922,269.24 | 115,036,633.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,570,000.00 | 33,499,213.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,179,400.00 | 15,369,180.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 65,172,869.24 | 66,168,240.48 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81,501,201.55 | 102,821,049.61 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 38,300,274.00 | 80,550,840.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,250,000.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 37,050,274.00 | 80,550,840.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 43,200,927.55 | 22,270,209.61 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 43,200,927.55 | 22,270,209.61 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (51,781,398.70) | 966,505,169.17 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 17,636,110.83 | 20,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 17,636,110.83 | 20,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (17,636,110.83) | (20,000.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (69,417,509.53) | 966,485,169.17 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,196,219,659.00 | 1,509,270,131.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 208,309.00 | 12,333,400.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 208,309.00 | 12,333,400.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 12,333,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 3,443,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 8,890,000.00 |
| 120009 | Бусад орлого | 208,309.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,196,011,350.00 | 1,496,936,731.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,026,885,200.00 | 1,263,093,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,263,093,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,026,885,200.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,595,250.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,762,250.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,833,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 156,530,900.00 | 233,843,431.00 |

| | | | |
|-------------|-----------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 156,530,900.00 | 233,843,431.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,186,759,659.00 | 1,395,532,239.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,186,759,659.00 | 1,395,532,239.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,105,814,557.45 | 1,290,280,240.18 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 818,806,375.13 | 938,172,665.56 |
| 210101 | Үндсэн цалин | 568,954,578.13 | 677,506,432.05 |
| 210102 | Нэмэгдэл | 178,151,175.00 | 210,029,460.39 |
| 210104 | Урамшуулал | 71,700,622.00 | 50,636,773.12 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,884,853.13 | 107,363,921.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,456,753.13 | 73,512,640.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,607,000.00 | 8,609,957.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,085,600.00 | 6,881,245.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,521,400.00 | 1,669,097.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,214,100.00 | 16,690,980.66 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 131,285,983.19 | 155,201,590.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,252,889.19 | 8,578,966.39 |
| 210302 | Түлш, халаалт | 125,720,094.00 | 146,192,624.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 313,000.00 | 430,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,899,968.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,472,650.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,071,300.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 825,818.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 3,352,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 494,600.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,683,600.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 17,051,328.00 | 23,999,380.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 945,400.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 14,675,728.00 | 23,999,380.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,430,200.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,340,000.00 | 4,999,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 340,000.00 | - |
| 210602 | Тавилга | 5,000,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | - | 4,999,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 394,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 394,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,803,900.00 | 12,217,490.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,939,900.00 | 3,443,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 8,774,090.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,348,150.00 | 48,326,193.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 30,365,893.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,348,150.00 | 17,960,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 80,945,101.55 | 105,251,999.61 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,744,174.00 | 82,981,790.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,250,000.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,494,174.00 | 82,981,790.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 43,200,927.55 | 22,270,209.61 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 43,200,927.55 | 22,270,209.61 |

| | | | |
|--------|---------------------------------------------------------------------|----------------|-----------------|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 9,460,000.00 | 113,737,891.21 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 9,460,000.00 | 54,381,381.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 9,460,000.00 | 54,381,381.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 9,460,000.00 | 54,381,381.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,460,000.00 | 54,381,381.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (9,460,000.00) | (54,381,381.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | 59,356,510.21 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 59,356,510.21 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--------------------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-----------------------------------------|
| C01 | 2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 522,082,593.56 | 407,936,422.64 | -114,723,162.16 | 815,295,854.04 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C08 | 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 522,082,593.56 | 407,936,422.64 | -114,723,162.16 | 815,295,854.04 |
| D01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 522,082,593.56 | 407,936,422.64 | -114,723,162.16 | 815,295,854.04 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -815,295,854.04 | -815,295,854.04 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 522,082,593.56 | 407,936,422.64 | -930,019,016.20 | 0.00 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 966,485,169.17 | 966,485,169.17 |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 522,082,593.56 | 407,936,422.64 | 36,466,152.97 | 966,485,169.17 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--------------------------------------------------|-----------------------|------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,528,378,600.00 | 1,427,643,411.18 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,528,378,600.00 | 1,427,643,411.18 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,436,294,000.00 | 1,344,661,621.18 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 974,238,200.00 | 938,172,665.56 |
| 210101 | Үндсэн цалин | 730,618,800.00 | 677,506,432.05 |
| 210102 | Нэмэгдэл | 217,952,300.00 | 210,029,460.39 |
| 210104 | Урамшуулал | 25,667,100.00 | 50,636,773.12 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 120,490,600.00 | 107,363,921.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,966,400.00 | 73,512,640.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,643,000.00 | 8,609,957.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,714,500.00 | 6,881,245.76 |

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------|------------------|------------------|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,924,300.00 | 1,669,097.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,242,400.00 | 16,690,980.66 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 191,107,200.00 | 155,201,590.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,500,000.00 | 8,578,966.39 |
| 210302 | Түлш, халаалт | 179,107,200.00 | 146,192,624.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,500,000.00 | 430,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 24,588,000.00 | 23,999,380.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,588,000.00 | 23,999,380.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 4,999,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,999,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,717,500.00 | 13,717,490.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,443,400.00 | 3,443,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,274,100.00 | 10,274,090.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 107,152,500.00 | 101,207,574.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 83,851,300.00 | 83,247,274.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 23,301,200.00 | 17,960,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 92,084,600.00 | 82,981,790.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 92,084,600.00 | 82,981,790.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 92,084,600.00 | 82,981,790.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,510,573,200.00 | 1,474,666,521.39 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,510,573,200.00 | 1,474,666,521.39 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,510,573,200.00 | 1,474,666,521.39 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 59,356,510.21 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн яамны 2023 оын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудиторгүй/ шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургууль 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 151,744.4 мянган төгрөгөөр буюу 18.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------------------------------------|------------------|------------------|-----------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 59,356.5 | 59,356.5 |
| Бараа материал | 43,142.6 | 68,082.6 | 24,940.0 |
| Үндсэн хөрөнгө | 772,153.3 | 839,601.1 | 67,447.8 |
| Нийт хөрөнгө | 815,295.9 | 967,040.2 | 151,744.4 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 815,295.9 | 967,040.2 | 151,744.4 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 815,295.9 | 967,040.2 | 151,744.4 |

Мөнгөн хөрөнгө 59,356.5 мянган төгрөгөөр өссөн нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлээр өссөн байна.

Нийт орлого 1,223,002.5 мянган төгрөгөөр буюу 101.6 хувиар өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн.

Мөн бараа материалын эхний үлдэгдлийг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого дээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Энэ нь сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоотоор “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах” чиглэлийн дагуу тохируулах бичилтүүд хийгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 204,715.9 мянган төгрөг буюу 16 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардалтай холбоотой зардал байна. Цалингийн зардал 108,551.9, нэмэгдэл цалин 31,878.3, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23,915.6, бараа үйлчилгээний бусад зардал 40,114.4 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,344,210.3 мянган төгрөг төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 63,312.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,280,898.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхэд 1,528,378.6 мянган төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр Улсын төсвөөс 1,263,093.3, орон нутгийн төсвөөс 233,843.4, өөрийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 12,333.4 мянган төгрөг бүгд 1,509,270.1 мянган төгрөгийн орлого бүрдэж, нийт

зардалд 1,427,643.4 мянган төгрөгийг зарцуулж 22,270.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэл т |
|-----|----------------------------------------------------------------------------|--------------|--------------|------------|-------------|
| 1 | 81801-Үдийн цай хөтөлбөр | 92,084.60 | 82,981.79 | 9,102.81 | 90% |
| 2 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 196,107.20 | 160,200.59 | 35,906.61 | 82% |
| 3 | 80112-Нийтлэг үйлчилгээ | 51,372.70 | 51,372.63 | 0.07 | 100% |
| 4 | 81806-Дотуур байрны үйлчилгээ | 40,708.10 | 38,735.03 | 1,973.07 | 95% |
| 5 | 81834- Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 945,890.00 | 901,855.30 | 44,034.70 | 95% |
| 6 | 81835-сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 113,323.40 | 109,545.59 | 3,777.81 | 97% |
| 7 | 80226-байр ашиглалтын үйлчилгээ | 4,109.60 | 4,109.60 | - | 100% |
| 8 | 80312- сургалт семинар | 2,054.80 | 2,054.50 | 0.30 | 100% |
| 9 | 81816-Зөв Монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 50,950.00 | 50,581.38 | 368.62 | 99% |
| 10 | 81605- Эрүүл мэндийг дэмжих | 4,726.10 | 4,726.10 | - | 100% |
| 11 | 81823- Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх | 9,246.70 | 9,147.50 | 99.20 | 99% |
| 12 | 81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах | 6,312.00 | 840.00 | 5,472.00 | 13% |
| 13 | 81848- Сурах бичгийн түрээс | 3,443.40 | 3,443.40 | - | 100% |
| 14 | 83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан | 5,500.00 | 5,500.00 | - | 100% |
| 15 | 83603- Нэмэлт дээд шатны төсөвөөс хуваарилсан | 2,550.00 | 2,550.00 | - | 100% |
| | НИЙТ | 1,528,378.60 | 1,427,643.41 | 100,735.19 | 93.4% |

Тогтмол зардал, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах арга хэмжээнүүд 19,108.47 мянган төгрөгөөр дутуу олгогдож төсөв хэмнэгдсэн харагдаж байна. Тус сургууль гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд төлөвлөгөөгөөр Боловсрол, шинжлэх ухааны газраас 6,312.0 мянган төгрөг зарцуулах эрх тавигдаж ирсэн буюу тус байгууллагын зүгээс төлөвлөөгүй, зарцуулах эрх тавиулах хүсэлт илгээгээгүй, гүйцэтгэлээр 840.0 мянган төгрөг байгаа нь туслах үйл ажиллагаа /ноолуурын үнэ/-ны зарцуулалтын дүн тусгагдсан байна.

Орон нутгийн төвлөрүүлэх шилжүүлгээр 22,270.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, Улсын төсвийн санхүүжилтийн мөнгөний эцсийн үлдэгдэл 59,356.51 мянган төгрөг байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн аудитор С.Энхтөр, аудиторын туслах Ш.Ундрах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ний 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1 хувиар буюу 12,558.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,791.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд гэрэл, цахилгааны зардал 3,326.0 мянган төгрөг, түлш, шатахууны зардал 20,472.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

- Гэрэл цахилгааны зардал өмнөх оноос дунжаар 63 хувиар нэмэгдсэн нь 2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал бага гарч байсан бол тайлант онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.
- Бараа үйлчилгээний бусад зардлууд дотор тээвэр шатахуун, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, хангамжийн бараа материал зэрэг зардлуудыг нийлүүлэх төсвийн төлөвлөлт, зардлын ангилалд өөрчлөлт орсон, мөн бараа материалын үнэ урд оноос 2-3 дахин өссөн нь нөлөөлөл үзүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.1-д “...тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой.” заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуульд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн залруулга, албан шаардлагыг 94% хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 599,511.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 671.5 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд акт тогтоож бүрэн биелүүлсэн, 8,474.1 мянган төгрөгийн 1 зөрчилд өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн, 590,365.9 мянган төгрөгийн шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд багтаан байршуулах, төсвийн хэмнэлттэй холбоотой алдаа, зөрчилд өгсөн нийт 3 зөвлөмжийг 90% биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|------------------|----------|------------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 671.5 | 1 | 671.5 | 100% |
| Албан шаардлага | 1 | 8,474.1 | 1 | 8,474.1 | 100% |
| Зөвлөмж | 3 | 590,365.9 | 3 | 590,365.9 | 90% |
| Нийт дүн | 5 | 599,511.5 | 5 | 599,511.5 | 94% |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38,298.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 37,743.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 555.1 мянган төгрөгийн залруулга хийж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Залруулга

Залруулсан: ХХОАТ-ын суутгасан мөнгийг шилжүүлээгүй, 555.1 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр илэрхийлснийг өглөгөөр тусгуулсан.

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтаар батлагдаагүй 18,549.3 мянган төгрөгийн ажил гүйлгээ гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авалтын мэдээллийг татварын нэгдсэн системд мэдээлсэн эсэхийг шалгах, мэдээлээгүй тохиолдолд харилцагч байгууллагад хандан системд шивүүлэх албан шаардлага өгсөн.

2. Илрүүлэлт: Тооллогын комисс тооллогыг чанартай хийж гүйцэтгээгүйгээс 19,194.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг орхигдуулан тоолсон байна.

Шийдвэрлэсэн нь:

Тооллогыг хөрөнгө тус бүрээр эд хариуцагчийн карттай тулган, чанар, үр дүнтэй тоолж, баталгаажуулах албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 12 мэдээ хугацаандаа байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллүүдийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан цаг хугацаанд тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--------------------------------------------------------------------------------------------------------|------------|-------|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ХХОАТ-ын суутгасан мөнгийг шилжүүлээгүй мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр илэрхийлснийг өглөгөөр тусгуулсан. | 1 | 555.1 | | | | | 1 | 555.1 | | | | |

